



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/405

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.7, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 тоот тогтоолоор баталсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын 2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 96 тоот тогтоолоор баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.1.5, 3.2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс заасан хугацаагаар сунгасугай.

2. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3.2.1.5, 3.2.2.2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиглахыг аж, ахуйн нэгж, байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.


3. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиглахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2018 оны 10-р сарын 29-ний өдрийн
А/405 тоот захирамжийн хавсралт



/Сунгалт/

№	Байршил	Аж ахуйн нэгжийн нэр	Үйлчилгээний газрын нэр	Үйлчилгээний чиглэл	Хугацаа
1	Сүхбаатар	"Гоё амт" ХХК	Монгол зоог	Зоогийн газар	2 жил
2		"Б энд Ти" ХХК	Чингис	Бар	2 жил
3		"Алтан ширээ" ХХК	Мишээл	Бар	2 жил
4	Алтанбулаг	"Хаяа улаан толгой" ХХК	Нарлаг	Хүнсний дэлгүүр	2 жил
5	Мандал	"Улаанбаатар төмөр зам" ТХТөв	Ган зам	Хүнсний дэлгүүр	2 жил
6		"Минж даваа ХХК	Эргэн дурсахуй	Бар	2 жил
7		"Ноцох дөл" ХХК	Тод-1	Хүнсний дэлгүүр	2 жил
8		"Манайцэцэг" ХХК	Ширхэнцэг	Хүнсний дэлгүүр	2 жил
9	Баянгол	"Намуун ар үр" ХХК	Намуун од	Мини маркет	2 жил
10	Хүдэр	"Хүдэр өсөх" ХХК	Намуун	Хүнсний дэлгүүр	2 жил
11	Зүүнбүрэн	"Болор эмүүн" ХХК	Буудай	Бар	2 жил
12	Ерөө	"Бугант на-дин" ХХК	Хайгуулчин	Хүнсний дэлгүүр	2 жил
13		"Ерөө харгана" ХХК	Миний	Хүнсний дэлгүүр	2 жил
14		"Бугант есөн ундраа" хоршоо	Есөн эрдэнэ	Хүнсний дэлгүүр	2 жил
15	Түшиг	"Түшиг шүтээн" ХХК	Баян уулс	Хүнсний дэлгүүр	2 жил
16	Сайхан	"Сайхан буурал" ХХК	Өгөөж	Хүнсний дэлгүүр	2 жил
17		"Арбайц трейд" ХХК	Шим	Супермаркет	2 жил
18		"Хөтөл өнө дэлгэр" ХХК	Өнө дэлгэр	Хүнсний дэлгүүр	2 жил
19		"Хөтөл вест" ХХК	Бэст шоп	Хүнсний дэлгүүр	2 жил
20	Шаамар	"Шар тохойн жаргаган" ХХК	Дүүрэн	Хүнсний дэлгүүр	2 жил
21	Цагааннуур	"Шинэ нуур" ХХК	Элгэмсэг-1	Мини маркет	2 жил
22	Баруунбүрэн	"Хангайнторх" ХХК	Бүрэнчимэг	Мини маркет	2 жил